

**БАЯНХОНГОР АЙМГИЙН БӨМБӨГӨР СУМЫН НУТАГТ ОРШИХ “ВОЯЖЕР  
МИНЕРАЛ РЕСУРСЕС” ХХК-ИЙН “ХӨХ БУЛАГ АЛТ-ЗЭСИЙН ҮНДСЭН  
ОРД” ТӨСЛИЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ  
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ  
БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: МҮ-020591  
АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 5502292

**ХЯНАСАН:**

БОАЖЯ-НЫ ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГО  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН МЭРГЭЖИЛТЭН

**БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:**

“ВОЯЖЕР МИНЕРАЛ РЕСУРСЕС” ХХК-ИЙН  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Д.БАТ-ЭРДЭНЭ

“ВОЯЖЕР МИНЕРАЛ РЕСУРСЕС” ХХК-ИЙН  
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЭРГЭЖИЛТЭН

Х.ГЭРЭЛМАА

2022 он

## АГУУЛГА

|     |  |     |
|-----|--|-----|
| 1.  | 2022 ОНЫ ДАЛТЫН ӨВӨР ОРДЫН АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....                                     | 6   |
| 1.1 | Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харъяалал .....  | 6   |
| 1.2 | 2022 оны ашиглалтын төлөвлөгөөний гүйцэтгэл: .....   | 7   |
| 1.3 | Уурхайн дэд бүтэц, барилга байгууламжууд: .....  | 12  |
| 1.4 | Хаягдлын байгууламж: .....   | 19  |
| 1.5 | Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа: .....  | 19  |
| 1.6 | “Вояжерминерал ресурсес” ХХК-ийн Байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд: .....                                       | 20  |
| 2   | ХӨХБУЛАГ УУРХАЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ.....                           | 21  |
| 3   | СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ....   | 21  |
| 3.1 | Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт .....   | 21  |
| 3.2 | Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл .....                  | 27  |
| 3.3 | Хөрсний чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл .....   | 32  |
| 3.4 | Урсгалын нөмрөгт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл .....   | 44  |
| 3.5 | Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл .....  | 49  |
| 4.  | НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....  | 51  |
| 5.  | БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....                                  | 57  |
| 6.  | НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....  | 65  |
| 7.  | ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....  | 66  |
| 8.  | ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....   | 66  |
| 9.  | ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....   | 72  |
| 10. | ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ .....  | 78  |
| 11. | ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ..... | 96  |
| 12. | ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ, ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ .....       | 98  |
|     | ДҮГНЭЛТ .....  | 101 |

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| Хүснэгт 1. Вояжерминерал ресурсес ХХК-ийн мэдээлэл.....   | 7  |
| Хүснэгт 2. Вояжерминерал ресурсес ХХК-ийн холбогдоа албан тушаалтнуудын мэдээлэл .....  | 7  |
| Хүснэгт 3. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын гүйцэтгэл.....   | 10 |
| Хүснэгт 4. Компанийн эзэмидэг тусгай зөвшөөрөл.....   | 20 |
| Хүснэгт 5. Холбогдох зөвшөөрлүүд.....   | 20 |
| Хүснэгт 6. Газар ашиглах зөвшөөрлүүд.....   | 20 |
| Хүснэгт 7. БОННУ-ний тайлангууд .....   | 20 |
| Хүснэгт 8. БОМТ-ний тайлангийн задаргаа.....  | 21 |
| Хүснэгт 9. Хөрсний механик бүрэлдэхүүн.....   | 36 |
| Хүснэгт 10. Хаягдлын сангийн шилжилт хөдөлгөөн, шүүрлийн хэмжилтийн үр дүн.....   | 38 |
| Хүснэгт 11. Ургамлын судалгаа хийсэн цэг .....  | 44 |
| Хүснэгт 12. Дотоод овоолгын координат .....   | 54 |
| Хүснэгт 13. Дүйцүүлэн хамгааллаар нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол.....  | 59 |
| Хүснэгт 14. Уурхай дээр хадгалагдаж буй аюултай хог хаягдлын бүртгэл .....  | 72 |
| Хүснэгт 15. Тоосонцорын хэмжилт хийсэн цэгүүдийн байршил .....  | 79 |
| Хүснэгт 16. Төслийн талбайн агаар дахь тоосны хэмжилтийн үр дүн, мг/м <sup>3</sup> .....  | 81 |
| Хүснэгт 17. Дуу шуугианы хэмжилтийн дүн, дБА.....   | 83 |
| Хүснэгт 18. Хөрсний дээж авсан цэгийн байршил.....  | 85 |
| Хүснэгт 19. Хөрсний механик бүрэлдэхүүн.....  | 89 |
| Хүснэгт 20. Дээжинд хийсэн химийн үзүүлэлт .....  | 89 |
| Хүснэгт 21. Хөрсөн дэх хүнд металлын үзүүлэлтүүд .....  | 89 |
| Хүснэгт 22. Гүний худгийн байршил.....  | 91 |
| Хүснэгт 23. Гүний худаг-1 ээс авсан усны химийн шинжилгээний үзүүлэлт .....   | 94 |
| Хүснэгт 24. Гүний худаг-2 оос авсан усны химийн шинжилгээний үзүүлэлт.....  | 94 |
| Хүснэгт 25. Уурхайн худгийн зүүн талд уурхайн ашиглалтын талбайд ойр орших малчны гар худгийн усны химийн шинжилгээний үзүүлэлт ..... | 95 |
| Хүснэгт 26. Химийн шинжилгээний үр дүнг Ундны ус, эрүүл ахуйн шаардлага, түүнд тавих хяналт .....                                     | 95 |

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

|   |    |
|---|----|
| Зураг 1. Хөхбулаг уурхайн байришил .....  | 6  |
| Зураг 2. Уурхайн байрзүйн зураг .....   | 6  |
| Зураг 3. 5-р хүдрийн биетийн уурхай.....  | 7  |
| Зураг 4. Тэсэлгээний холболтын схем, аюулгүй бүсийн зураг.....                                      | 9  |
| Зураг 5. Уурхайн ерөнхий дэвсгэр зураг.....   | 11 |
| Зураг 6. Уурхайн баяжуулах үйлдвэр.....   | 12 |
| Зураг 7. Ил уурхай.....   | 12 |
| Зураг 8. Уурхайн авто граж, сэлбэгийн агуулах, засварын хэсэг.....                                  | 13 |
| Зураг 9. Тэсрэх бодисын агуулах .....   | 14 |
| Зураг 10. Шатахуун түгээх агуулах .....   | 14 |
| Зураг 11. Удирдлагын байр.....  | 15 |
| Зураг 12. Ажилчдын гэр кемп болон амрах байр.....   | 15 |
| Зураг 13. 1 ОО болон халуун ус, 2 Угаалгын газар .....  | 16 |
| Зураг 14. Угаалгын өрөө.....  | 16 |
| Зураг 15. Ажилчдын ОО.....  | 17 |
| Зураг 16. Шүршүүр.....  | 17 |
| Зураг 17. Дэд станц.....  | 18 |
| Зураг 18. Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн шугам хоолой .....                                   | 19 |
| Зураг 19. 2-р худаг .....   | 19 |
| Зураг 20. 1-р худаг .....   | 19 |
| Зураг 21. Замын тоосжилт дарах усалгаа хийж буй байдал.....   | 22 |
| Зураг 22. Усалгаа хийгдэж буй замын байршилүүд .....  | 22 |
| Зураг 23. Шинээр байрлуулсан хурдны хязгаарын тэмдэг.....   | 23 |
| Зураг 24. Замын засвар, арчилгаа хийж буй байдал .....  | 23 |
| Зураг 25. Тоосны шинжлэгээ хийж буй байдал .....  | 24 |
| Зураг 26. Дуу чимээний шинжлэгээ .....  | 24 |
| Зураг 27. Тоос хэмжигч.....   | 24 |
| Зураг 28. Дуу чимээ хэмжигч.....  | 24 |
| Зураг 29. Дуу чимээ хэмжиж буй нь.....  | 25 |
| Зураг 30. Хайрган хучилттай болгож засварласан замууд.....  | 26 |
| Зураг 31. Замын засвар, арчилгаа хийж буй байдал .....  | 26 |
| Зураг 32. Уурхайн замын сүлжээний зураг.....  | 27 |
| Зураг 33. Усны эх үүсвэрийн хамгаалалтын байдал .....   | 28 |
| Зураг 34. Гүн өрмийн худгийн тоолуурын баталгаажилт, ус ашиглалтын бүртгэл .....                    | 29 |
| Зураг 35. Хаягдлын сангийн хуурай үлдэгдэл.....   | 30 |
| Зураг 36. 2019-2021 онуудад нөхөн сэргээлт хийсэн талбайнууд .....                                  | 33 |
| Зураг 37. Газрын хянан баталгаа хийлгэсэн төлбөрийн баримт, батлагдсан тайлангийн нүүр хуудас ..... | 35 |
| Зураг 38. 2018 онд ургамлын төлөв байдал.....   | 36 |
| Зураг 39. 2022 онд ургамлын төлөв байдал.....   | 36 |
| Зураг 40. Хэмжилт хийж буй багаж хэрэгсэл.....  | 37 |
| Зураг 41. Хаягдлын сангийн хэмжилт хийгдэж буй мониторингийн цэгүүд .....                           | 38 |
| Зураг 42. Нийтийн бие засах газар /эр, эм/.....   | 40 |
| Зураг 43. Хаягдал бохир хуримтлуулан соруулах цэг, агааржуулалтын хоолой.....                       | 41 |
| Зураг 44. Бохир ус зайлуулах болон халдваргүйтгэлийн гэрэнүүд .....                                 | 42 |
| Зураг 45. Хог хаягдал болон бохир ус зайлуулах цэгийн зөвшөөрөл .....                               | 43 |
| Зураг 46. Цэвэрлэгээ, ариутгал хийж буй нь.....   | 43 |
| Зураг 47. Ургамлын судалгаа хийсэн цэгийн байришил .....  | 44 |
| Зураг 48. Уурхайн ашиглалтын талбайн ойр орчимд ургамлын судалгаа хийсэн орчны байдал.....          | 45 |
| Зураг 49. Орчны тохижилтын байдал.....  | 46 |
| Зураг 50. Ногоон байгууламжийн арчилгаа, усалгаа .....  | 47 |
| Зураг 51. Уурхайн орчинд тариалсан мод.....   | 48 |
| Зураг 52. 24 цагийн харуул хамгаалалтын байр.....   | 49 |
| Зураг 53. Шувуу үргээгчийн бүрэн бүтэн байдал.....  | 50 |




|   |     |
|---|-----|
| Зураг 54. Орчны цэвэрлэгээ болон гуу жалгаар шалгалт хийсэн байдал.....                             | 51  |
| Зураг 55. Нөхөн дүүргэлт хийхээр төлөвлөсөн газрын байришил.....                                    | 52  |
| Зураг 56. 1, 2, 3-р хүдрийн биетийн ухашийн 2022 оны нөхөн дүүргэлт .....                           | 52  |
| Зураг 57. 1, 2, 3-р хүдрийн биетийн ухашийн 2022 оны нөхөн дүүргэлтийн зүсэлт .....                 | 53  |
| Зураг 58. 5-р хүдрийн биетийн дотоод овоолгын нөхөн сэргээлт .....                                  | 54  |
| Зураг 59. Нөхөн сэргээлтийн ажлын гүйцэтгэлийн зураг.....   | 56  |
| Зураг 60. Мод үржүүлгийн газрын хүлэмж барьж буй нь .....   | 57  |
| Зураг 61. Дүйцүүлэн хамгааллаар нөхөн сэргээх газрын байришил.....                                  | 58  |
| Зураг 62. Нөхөн сэргээлт хийгдсэн талбайн байришил.....   | 59  |
| Зураг 63. Дүйцүүлэн хамгааллын нөхөн сэргээлтийн ажлын зураг.....                                   | 64  |
| Зураг 64. 2019-2021 онуудад нөхөн сэргээлт хийсэн талбайнууд .....                                  | 65  |
| Зураг 65. Химийн бодисын тусгай зөвшөөрөл.....  | 67  |
| Зураг 66. Химийн тайлангийн бичиг баримтууд.....  | 68  |
| Зураг 67. Химийн бодисын агуулахын стандартын хангалт .....   | 70  |
| Зураг 68. Гамингаас хамгаалах төлөвлөгөө, аюулын үед хэрэгжүүлэх төлөвлөгөөний батлагдсан нүүр..... | 71  |
| Зураг 69. Аюултай хог хаягдлыг төрөлжүүлэн хадгалж буй байдал .....                                 | 73  |
| Зураг 70. Аюултай хог хаягдлын гэрээнүүд.....   | 74  |
| Зураг 71. Нийтийн цэвэрлэгээ.....   | 75  |
| Зураг 72. Хог хаягдлын гэрээ.....   | 76  |
| Зураг 73. Хог хаягдлын тээвэрлэлт, төлбөрийн баримт .....   | 77  |
| Зураг 74. Хаягдал тосыг хадгалж буй байдал.....   | 78  |
| Зураг 75. Тоосонцорын болон дуу шуугианы хэмжилтийн цэгийн байришлын зураг.....                     | 79  |
| Зураг 76. Гар багажаар тоосонцорын хэмжилт хийж буй байдал .....                                    | 82  |
| Зураг 77. Багаж ашиглан дуу шуугиан хэмжсэн зурган мэдээлэл.....                                    | 84  |
| Зураг 78. Гар утасны апп ашиглан дуу шуугиан хэмжсэн зурган мэдээлэл.....                           | 85  |
| Зураг 79. Хөрсний дээж авсан цагийн байришлын зураг .....   | 86  |
| Зураг 80. Хөрсний шинжилгээний дүгнэлтүүд.....  | 88  |
| Зураг 81. Хөрсний дээж авч буй байдал .....   | 91  |
| Зураг 82. Худгийн байришлын зураг.....  | 91  |
| Зураг 83. Усны шинжилгээний дүгнэлтүүд.....   | 93  |
| Зураг 84. Усны дээж авч буй байдал .....  | 94  |
| Зураг 85. Шинжилгээний төлбөрийн баримтууд .....  | 96  |
| Зураг 86. Аудитын тайлангийн баримтууд .....  | 97  |
| Зураг 87. Нөхөн сэргээлтийн барьцаа тушаасан баримт.....  | 98  |
| Зураг 88. Автомашиныг татаж гаргаж буй байдал .....   | 100 |


# 1. 2022 ОНЫ ДАЛТЫН ӨВӨР ОРДЫН АШИГЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

## 1.1 Төсөл хэрэгжүүлж буй газрын засаг, захиргааны харьяалал

*Төслийн харьяаллын байршил:* Хөхбулаг уурхай нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын Улаансайр багийн нутаг дэвсгэрт харьяалагддаг бөгөөд Улаанбаатар хотоос баруун зүгт 750 км, Баянхонгор аймгийн төвөөс баруун зүгт 120 км, Бөмбөгөр сумын төвөөс хойд зүгт 20 км-т байрладаг.



Зураг 1. Хөхбулаг уурхайн байршил



Зураг 2. Уурхайн байрзүйн зураг

*Төслийн ангилал:* Хөхбулаг уурхай нь алт-зэсийн үндсэн ордыг ил уурхайн аргаар олборлох, боловсруулах уул уурхайн төсөл бөгөөд 2011 оноос тусгай зөвшөөрлийг шилжүүлэн авснаар

хүдэр баяжуулах үйлдвэр барьж байгуулан ашиглалтад оруулах, тоног төхөөрөмжийг суурьлуулах, ажилчдын кемп байгуулах болон бусад тохижилтын ажлууд хийгдэж, баяжуулах үйлдвэрийг улсын комисст хүлээлгэн өгснөөр ил уурхайн олборлолт болон хүдэр баяжуулж боловсруулах үйл ажиллагаа явагдаж байна.

**Жонш баяжуулах үйлдвэрийн төслийг хэрэгжүүлэгч аж ахуйн нэгжийн мэдээлэл:**

Хүснэгт 1. Вояжерминерал ресурсес ХХК-ийн мэдээлэл


| ААНэгжийн нэр                | Улсын бүртгэлийн дугаар | Үйл ажиллагааны чиглэл                                    | ААН-ийн хаяг, байршил  |
|------------------------------|-------------------------|---|--|
| “Вояжерминерал ресурсес” ХХК | 9011299047              | Төлбөр эсвэл гэрээний үндсэн дээр хийгдэх бөөний худалдаа | Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимп, Аюуд тауэр, 10-р байр, 1002 тоот |

Хүснэгт 2. Вояжерминерал ресурсес ХХК-ийн холбогдоа албан тушаалтнуудын мэдээлэл

| № | Овог, нэр    | Албан тушаалын нэр |
|---|--------------|--------------------|
| 1 | Д.Бат-Эрдэнэ | Гүйцэтгэх захирал  |
| 2 | Ю.Батаа      | Уурхайн дарга      |
| 3 | Э.Наран-Очир | Уурхайн дарга      |
| 4 | Б.Азжаргал   | ХАБЭА-ийн инженер  |
| 5 | Д.Батням     | Маркшейдер         |
| 6 | Г.Алтангэрэл | Уулын мастер       |

**1.2 2022 оны ашиглалтын төлөвлөгөөний гүйцэтгэл:**

**Бүтээгдэхүүн үйлдвэрлэл:** 2022 онд урьдчилсан тооцоогоор Хөхбулаг ордын 5-р биетэд 97.2 мян.м<sup>3</sup> хөрс хуулалт хийж, 17.4 мян.тн хүдэр олборлож, нийт 102.5 мян.м<sup>3</sup> уулын цулын ажил гүйцэтгэсэн байна. (Энэ мэдээлэл нь уулын ажлын тайлангаар баталгаажина). Тус уурхай болон баяжуулах үйлдвэр нь 2022 онд 3 сарын хугацаанд үйл ажиллагаа явагдсан бөгөөд дэлхий нийтийг хамарсан цар тахлаас үүссэн эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдал, давагдашгүй хүчин зүйлийн улмаас бусад хугацаанд үйл ажиллагаа бүрэн зогссон.



**Уурхайн нээлт:** Уурхайн нээлтийг үндсэн нээгч налуу траншейгаар нээн ашиглахаар тооцсон. Хөхбулаг алт-зэсийн үндсэн ордын хүдрийг баруунаас зүүн тийш уулын ажлын ахилттайгаар

олборлохоор төлөвлөсөн. Хөрс хуулалт болон хүдэр олборлолтын ажлыг урьдчилан өрөмдлөг тэсэлгээний ажлын тусламжтайгаар сийрэгжүүлэлт хийсний дараа экскаватороор хутган автосамосвалд ачиж, хөрсний чулуулгийг ил уурхайн гадаад овоолгод, хүдрийг баяжуулах үйлдвэрийн хүдрийн овоолго хүртэл тээвэрлэн байршуулж байна.

*Уулын ажил:* Тайлант хугацаанд ордын V биетийн олборлолтоос үлдсэн 16000 тн хүдрийг боловсруулж, IV хүдрийн биетээс олборлох 15683 тн, нийт 31683 тн хүдэр олборлохоор төлөвлөсөн. Уулын хэсэг нь нийт 20 хүний бүрэлдэхүүнтэй, өдрийн 1 ээлжээр ажилласан. Хөрс хуулалт болон хүдэр олборлолтод CAT-349 маркийн экскаватор, хөрс болон хүдэр тээвэрлэлтэд HOWO маркийн 25тн-ын даацтай автосамосвал, хөрсний отвол түрж тэгшлэхэд Shantui SD-45 маркийн бульдозер, Sem-660B маркийн утгуурт ачигч зэрэг техникүүдийг ашиглаж уулын ажлыг гүйцэтгэлээ.

*Өрөмдлөг тэсэлгээ:* Өрөмдлөгийн ажлыг “Вояжер Минерал Ресурсес”ХХК өөрийн өмчид байгаа БНХАУ-д үйдвэрлэсэн HF-385Y маркийн өрмийн машиныг ашиглалаа.

Хүдрийн биетийн бат бөх Протодьяконовын ангиллаар 15, хүдрийн эзлэхүүн жин дунджаар 3.2 тн/м<sup>3</sup> байна. Ил уурхайн хөрсний чулуулаг нь боржиндиорит, карбонатлаг-силикатлаг найрлагатай шохойн чулуу зэргээс бүрдэх бөгөөд чулуулгийн эзлэхүүн жин дунджаар 2.5 тн/м<sup>3</sup>, бат бөх 16 байдаг. Уурхай нь 2018 оноос эхлэн өрөмдлөг тэсэлгээ, олборлолтын ажлыг хийж байгаа бөгөөд ордын талбайд өмнө нь хийгдсэн өрөмдлөг, тэсэлгээний ажлын үр дүнгүүдэд тулгуурлан тухайн ордын хүдрийн биет, чулуулгийн бат бэх, ил уурхайн олборлолтын аргачлал, орон зайд зохицсон өрөмдлөгийн гүн болон торлолын оновчтой зайг тодорхойлж, амжилттай гүйцэтгэж байгаа билээ. Дээрх хүдрийн биетүүдэд илүү өрөмдлөг хийгээгүй бөгөөд тэсэлгээний нэгж блокын өрөмдлөгийн торлол 3.6x4.2м (хөрс), 3x3.5м (хүдэр), цооногийн гүн 5м-ээр зохион байгуулсан. Ингэснээр чулуулгийн бутлагдал сайтай, тэсрэх бодисын зарцуулалт бага, тэсэлгээний үеийн хүдрийн бохирдолыг хамгийн бага байлаа.

2022 онд нийт 102684м<sup>3</sup> уулын цулын ажил гүйцэтгэсэн бөгөөд үүнээс 52157м<sup>3</sup>-ийг нийт 8 тэсэлгээний ажлаас сийрэгжүүлсэн байна. 5-р биетийн гадаргуу болон гадаргууд ойр байгаа (ил уурхайн түвшин дээд хэсгүүд) чулуулаг өгөршиж бутарсан, ан цавшилт ихтэй байсан тул 50527м<sup>3</sup> уулын цулыг өрөмдлөг тэсэлгээний ажилгүйгээр шууд олборлосон.

Тэсэлгээний нэгж блокийн хэмжээг ил уурхайн орон зай, ажлын гүйцэтгэл, гадаргуугын хэлбэр, аюулгүй ажиллагаа зэргийг харгалзан үзэж зохион байгуулав. Уг ажлыг туслан гүйцэтгэгч “Майн Тейх Бласт”ХХК-иар гүйцэтгүүлсэн бөгөөд аюулгүй ажиллагаа болон бусад тэсэлгээтэй холбоотой ажилбаруудыг тус компани бүрэн хариуцдаг. Тэсэлгээний аюулгүй зайг тэсрэх бодисын зарцуулалтаас хамааруулан тус бүрт холбогдох инженерүүд тооцоолдог.






Хүснэгт 3. Өрөмдлөг, тэсэлгээний ажлын гүйцэтгэл

| №           | Тэсэлгээний № | Өрөмдлөг, м    |               |                 |            | Тэсэлгээ     |               |                   |                    |                   |                   |                |           |              |             |               |             |
|-------------|---------------|----------------|---------------|-----------------|------------|--------------|---------------|-------------------|--------------------|-------------------|-------------------|----------------|-----------|--------------|-------------|---------------|-------------|
|             |               | Хөрс (3.6x4.2) |               | Хүдэр (3.0x3.5) |            | Анфо /кг/    | Эм иульс /кг/ | 32мм Эмиульс /кг/ | Искра-6м /500мс/ш/ | Искра-6м /25мс/ш/ | Искра-6м /42мс/ш/ | Галын блят /ш/ | ОШП       | Хөрс, м3     | Хүдэр, м3   | Уулын цул, м3 | Зарцуулалт  |
| 1           | 35            | 35             | 173           | 26              | 129        | 2480         |               | 18.6              | 62                 | 10                | 58                | 2              | 3         | 2625         | 1354        | 3979          | 0.62        |
| 2           | 36            | 89             | 358           |                 |            | 3120         |               | 26.7              | 89                 | 9                 | 80                | 2              | 3         | 5544         |             | 5544          | 0.56        |
| 3           | 37            | 69             | 312           | 48              | 217        | 4400         | 240           | 35.4              | 117                | 23                | 97                | 1              | 3         | 4639         | 2239        | 6878          | 0.67        |
| 4           | 38            | 51             | 230           | 61              | 270        | 3600         |               | 33.6              | 122                | 10                | 112               | 2              | 4         | 3477         | 2916        | 6393          | 0.56        |
| 5           | 39            | 116            | 579           |                 |            | 4150         |               | 34.8              | 126                | 10                | 110               | 2              | 4         | 8754         |             | 8754          | 0.47        |
| 6           | 40            | 214            | 1028          |                 |            | 7930         |               | 72                | 214                | 20                | 200               | 3              | 3         | 7930         |             | 7930          | 0.51        |
| 7           | 41            | 74             | 349.4         | 68              | 345        | 5680         |               | 62.1              | 142                | 34                | 127               | 2              | 4         | 5680         |             | 5680          | 0.62        |
| 8           | 42            | 95             | 462.9         |                 |            | 2850         |               | 48                | 95                 | 36                | 70                | 2              | 2         | 6999         |             | 6999          | 0.41        |
| <b>Нийт</b> |               | <b>743</b>     | <b>3492.3</b> | <b>203</b>      | <b>961</b> | <b>34210</b> | <b>240</b>    | <b>331.2</b>      | <b>967</b>         | <b>152</b>        | <b>854</b>        | <b>16</b>      | <b>26</b> | <b>45648</b> | <b>6509</b> | <b>52157</b>  | <b>0.66</b> |

*Ажилллах горим:* 2022 онд ил уурхайн хүчин чадал 92 хоногт 15.7 мян.тн хүдэр олборлохоор /1, 2, 3 болон 4-р сард олборлолт явуулах/ тооцсон. Баяжуулалтын ажлыг 180 хоног явуулахаар тооцсон боловч 2022 оны 4-р сарын 30 хүртэл ажиллаад уурхай болон баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа бүрэн зогссон. 2022 оны 10-р сарын сүүлээс Баяжуулах үйлдвэрийн их засварын ажлууд хийж гүйцэтгэсэн болно. Уурхайд 2022 оны 1-р сарын 01-ээс 2022 оны 4-р сарын 30 хүртэл нийт 120 хоног 87 ажилчид, 2022 оны 11-р сарын 16-аас 2022 оны 12-р сарын 31-н хүртэл 43 хоног, 2022 оны 5-р сарын 01-ээс 11-р сарын 16 хүртэл 10 ажилчин 196 хоног ажилласан байна.

*Хөрс хуулалт, хүдэр олборлолт, ил уурхай болон овоолго зохион байгуулалт:* Ил уурхайн шимт хөрсийг хуулахдаа 0.2-0.5 метрийн зузаантай хуулан утгуурт ачигчаар автосамосвалд ачин уурхайн олборлолтын талбайн гадна удаан хугацаанд хадгалах овоолгод зөөвөрлөж хадгалсан ба үржил шимт хөрсийг уурхайн нөхөн сэргээлтэд эргүүлэн ашиглахаар нөөцөлж байна. Уулын ажлыг ТЭЗҮ-нд тусгагдсаны дагуу гүйцэтгэж ажиллаа.





Зураг 5. Уурхайн ерөнхий дэвсгэр зураг



1.3 Уурхайн дэд бүтэц, барилга байгууламжууд:



Зураг 6. Уурхайн баяжуулах үйлдвэр



Зураг 7. Ил уурхай



Уурхайн барилга байгууламжууд: Хөхбулаг алт-зэсийн үндсэн ордыг ашиглах төлөвлөгөө, Техник эдийн засгийн үндэслэл болон бусад бичиг баримтуудад уурхайн гол барилга, байгууламжууд нь MV-020591 тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайд байрлаж байхаар тусгасан байна. Үүнд:

1. Уурхайн авто засварын газар болон сэлбэгийн агуулах: Уурхайн засварын цех, сэлбэгийн агуулах, авто гражуудыг уурхайн хотхоны баруун талд 200-300 м зайд 2 давхар галд тэсвэртэй буюу шатдаггүй сендвичэн материалаар барьж байгуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.



Зураг 8. Уурхайн авто граж, сэлбэгийн агуулах, засварын хэсэг

2. Тэсрэх материалын агуулах: Тэсрэх материалын агуулахыг ашиглалтын талбайд ил уурхай болон уурхайн тосгон зэрэг барилга байгууламж объектуудаас зүүн тийш 500м-ийн зайтай барьж байгуулсан. Уурхайн жилийн хэрэглээ 300 орчим тн тэсрэх бодис хэрэглэнэ. Иймээс агуулахын багтаамж нь уурхайн нэг сарын хэрэглээг хангаж байхаар 50 тн-ы багтаамжтай байхаар төлөвлөж байгуулсан.







Зураг 9. Тэсрэх бодисын агуулах

**3. Түлш шатах тослох материалын хангамж:** Шатах тослох материалын түр агуулах болон ШТС нь торон хашаагаар хүрээлэгдсэн задгай талбайд үйлдвэрлэлийн цогцолбороос 100 м-ээс доошгүй зайд, уурхайн нэг сарын хэрэглээг хангах хэмжээний 50 тн-ыг багтаамжтай 2ш ёмкость бүхий ШТС, уурхайн түлш шатахуун, шатах тослох материалыг Баянхонгор аймгийн төвөөс зөөвөрлөж хангадаг бөгөөд ШТС-ыг галын аюулгүй байдлын үүднээс гал унтраах багаж хэрэгсэлээр хангаж, тоноглон ашиглаж байна.



Зураг 10. Шатахуун түгээх агуулах

**4. Уурхайн захиргаа удирдлагын байр:** Уурхайн захиргаа болон инженер техникийн ажилчдыг ажиллах нөхцөлөөр хангах үүднээс уурхайн талбайд уурхайн захиргааны төв оффис барьж байгуулах ба үүнд уурхайн инженер техникийн ажилчид, санхүү эдийн засаг, уурхайн дарга, ажилчдад ажлын зааварчилгаа /наряд/ өгөх болон хөдөлмөр хамгаалал



аюулгүй ажиллагааны сургалтын өрөө хурлын заал, уурхайн эмнэлэгийн хэсэг гэх мэт өрөө тасалгаатай байна.



Зураг 11. Удирдлагын байр

5. Уурхайн ажилчдын хотхоны барилга байгууламж: Уурхайн хотхон 150 хүний багтаамж бүхий хоол цайны газар, сууц байхаар төсөлд тусгасан бөгөөд цаашид өргөтгөх боломжтой юм. 2022 оны байдлаар ажилчдын хотхон нь сендвичэн барилга, мөн 19 ш гэр кемп ашиглаж байна. Уурхайн кемпэд ажилчдын хоолны газар, уурхайн эмнэлэгийн хэсэг байрлаж байна.



Зураг 12. Ажилчдын гэр кемп болон амрах байр



6. ОО болон угаалгын газар: Гэр кэмийн зүүн урд талд ажилчдын ОО болон халуун ус, угаалгын газрыг байгуулан ашиглаж байна.



Зураг 13. 1 ОО болон халуун ус, 2 Угаалгын газар



Зураг 14. Угаалгын өрөө





Зураг 15. Ажилчдын ОО



Зураг 16. Шүршүүр

**7. Хаягдал хадгалах байгууламж:** Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуй нь Зунпируэ ХХК-тай хамтран ашигладаг бөгөөд 380м урт, 240м өргөн, 4.12м гүн, 375965 м<sup>3</sup> эзэлхүүнтэй, геомембран доторлогоотой, үйлдвэрээс хаягдлыг насосны тусламжтайгаар хоолойгоор шахаж, хаягдлын сан дахь хөвөгч насосын системээр үйлдвэрт 80%-ийг буцаан шахах технологиор усны эргэлт явагддаг. Жил бүр хуурай хаягдлаас дээж авч байгальд хортой элементийн агуулгыг тодорхойлуулан, хортой элементийн агуулга илэрсэн нөхцөлд саармагжуулсны дараа далангийн өндөрлөгөөнд хэрэглэж байна. 2019 онд Баяжуулах үйлдвэрийн өргөтгөлийн ажилтай холбогдуулан шинээр 371.1м урт, 255.7м өргөн, 6.0м гүн, 53000м<sup>3</sup> эзэлхүүнтэй хаягдал ус нөөцлөх хаягдлын байгууламж байгуулсан.

**Дулаан хангамж:** Баяжуулах үйлдвэрийн барилга, уурхайн захиргаа, удирдлагын байр, ажилчдын кемп, ОО, угаалгын газрууд бага оврын нам даралтын зуух ашигладаг бөгөөд гэр кемпүүд гар галлагаатай.

**Цахилгаан хангамж:** Уурхайг нийтэд нь цахилгаанаар хангах зорилгоор Бөмбөгөр-Заг чиглэлийн 35 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын № 87-р тулгуураас салбарлуулан шугамын хажууд 35/15 кВ-н бууруулах трансформатор бүхий дэд станцыг хамгаалалтуудын хамт суурилуулан ашиглаж байгаа ба уг трансформаторын үзүүлэлт нь 2000/35/15 чадал бүхий трансформатор юм. Уурхай хүртэл 15 кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугамыг АС-70 маркийн утастай MNS 4232-2005, MNS:4232-2006 стандартын шаардлага хангасан төмөр бетон тулгуураар 12 км татсан байна. Уурхай дээр 800 кВА чадалтай КТПН-750 маркийн 15/0.4 кВ-ын 2 ш, 93 кВА чадалтай АТП-75 маркийн 15/0.4 кВ-ын 1 ш трансформатор суурилагдан ажиллаж байна. Нийт суурилагдсан хүчин чадал 1.7 мВт буюу 1693 кВА чадалтайгаар ажиллаж байна.



Зураг 17. Дэд станц

**Усан хангамж:** Баяжуулах үйлдвэрийн нийт хэрэгцээт усны 85.0 %-ийг эргэлтийн усан хангамжаар шийдвэрлэх бөгөөд үлдсэн 15.0 %-ийг цэвэр усаар хангахаар ТЭЗҮ-д тооцоолсон. Баяжуулах үйлдвэрт шаардлагатай цэвэр усыг компанийн өөрийн хөрөнгөөр ашиглалтын талбай дотор гаргуулсан 2ш гүн өрмийн худгаас /83-86м-ийн гүнтэй/ хангаж байна.

Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн хэсэг нь эргэлтийн усан сан, технологийн усны шугам хоолой, тоног төхөөрөмжийн хөргөлтийн усны шугам хоолой, тоос дарах болон бусад шаардлагатай усны шугам хоолой, аваарын усны сан, даралтын насос зэргээс бүрдэнэ. Эргэлтийн ус дамжуулах насосны станцын гарах аманд урсацын хэмжээ, даралтыг шалгах хэмжүүр суурилуулсан. Үйлдвэрийн төв байшин доторх баяжуулах ба бусад дамжлагад мөн дээрх хэмжих багажийг тохируулж хяналтын өрөөнөөс системийн ажлын байдал болон усны зарцуулалтад хяналт тавиж байна. Баяжуулах үйлдвэрийн хажууд цэвэр усны 1 ш, эргэлтийн усны 2 ш /тус бүрдээ 50 м<sup>3</sup>/ бүхий эзэлхүүнтэй усан сан байрлуулан, гүний худгаас ирэх цэвэр усыг үйлдвэрийн цэвэр усны 2.60\*9.50=50 м<sup>3</sup> багтаамжтай усан санд хуримтлуулан усны хэрэгцээг хангаж байна.

Тус уурхайн усны хэрэглээ нь унд ахуйн хэрэглээ, ил уурхайн технологийн, баяжуулах үйлдвэрийн технологийн ус хэрэглээнээс бүрдэнэ. 2022 онд баяжуулах үйлдвэрт 2742.22м<sup>3</sup>, ногоон байгууламжийн усалгаанд 433.5м<sup>3</sup>, унд ахуйн хэрэглээнд 1291.28м<sup>3</sup>, нийтдээ 4467м<sup>3</sup> ус хэрэглэсэн байна.





Зураг 18. Баяжуулах үйлдвэрийн усан хангамжийн шугам хоолой



Зураг 19. 2-р худаг

Зураг 20. 1-р худаг

**1.4 Хаягдлын байгууламж:** Хүдэр баяжуулах үйлдвэрийн хаягдлын сан нь 3 хэсгээс бүрдэхээр ТЭЗҮ-д тусгасан.

Хаягдлын сан – 1: Эзлэхүүн 32000 м<sup>3</sup> хүчин чадалтай ба баяжуулах үйлдвэрээс урд зүгт 250 м зхйд байрлана.

Хаягдлын сан – 2: Эзлэхүүн 104000 м<sup>3</sup> хүчин чадалтай, баяжуулах үйлдвэрээс урд зүгт 650 м зайтай

Хаягдлын сан – 3: Эзлэхүүн 92500 м<sup>3</sup> хүчин чадалтай, баяжуулах үйлдвэрээс зүүн зүгт 650 м зайд байрлана. Нийт хаягдлын сангийн хүчин чадал 228500 м<sup>3</sup> ба автосамосвалаар хаягдлыг тээвэрлэн санд байршуулна. Хаягдлын сан – 1 үйлдвэр ажиллаж эхлэхээс өмнө ашиглалтад орсон. Дараагийн хаягдлын сангуудыг ашиглалтад бэлэн болгох ажлыг үйлдвэрээс гарах хаягдлын хэмжээ, хаягдалд хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн хяналтын шинжилгээний үр дүнгээс хамааруулан зохион байгуулна.

#### 1.5 Баяжуулах үйлдвэрийн үйл ажиллагаа:

Баяжуулах үйлдвэр нь 2018 онд ашиглалтад орсон ба Shandong Huali Electric Motor Group болон Fulinkuangii компаниудын нунтаглан баяжуулах, шүүн өтгөрүүлэх багц тоног төхөөрөмжүүдийг угсарч суурилуулан ажиллаж байна. Уурхайгаас ирэх -400 мм-ийн ширхэглэлтэй хүдрийг 2 шатны бутлалт, 1 шатны нунтаглалтаар -0.074 мм (75-80%) болгож үндсэн болон 3 шатны цэвэрлэгээ, 3 шатны хяналтын флотациар баяжуулан алт-зэсийн хам баяжмал үйлдвэрлэх бөгөөд хаягдлыг өтгөрүүлэгч, шүүлтүүрийн тусламжтай шүүн шахаж хуурай хаягдал гаргана. Баяжуулах үйлдвэрийн жилийн хүчин чадал 89.74 мян.тн бөгөөд үйлдвэрийн үндсэн тоног төхөөрөмжийн ашиглалт 90%-тай ажиллана. Баяжуулах үйлдвэрийн технологийн хаягдлыг өтгөрүүлэх, шүүх

төхөөрөмжөөр усгүйжүүлж, эргэлтийн усыг технологид буцаан ашиглах, үйлдвэрээс чийглэг багатай хуурай хаягдал хаях ба уурхайн ашиглалт дууссан хоосон орон зайд нөхөн дүүргэлт хийнэ.

### 1.6 “Вояжерминерал ресурсес” ХХК-ийн Байгаль орчны үнэлгээ, холбогдох зөвшөөрлүүд:

#### 1.6.1 Компанийн эзэмшдэг тусгай зөвшөөрлүүд:

*Хүснэгт 4. Компанийн эзэмшдэг тусгай зөвшөөрөл*

| № | Тусгай зөвшөөрлийн төрөл                    | Дугаар    | Хүчинтэй хугацаа      |
|---|---|-----------|-----------------------|
| 1 | Ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл | MV-020591 | 2016.07.01-2046.07.01 |
|   |   |           |                       |

#### 1.6.2 Байгаль орчны холбогдох зөвшөөрөл

*Хүснэгт 5. Холбогдох зөвшөөрлүүд*

| № | Зөвшөөрлийн зориулалт                                       | Дугаар        | Хүчинтэй хугацаа      |
|---|---|---------------|-----------------------|
| 1 | Химийн хорт болон аюултай бодис ашиглах                     | 0001645       | 2020.05.26-2023.12.31 |
| 2 | Усны боломжит нөөцийн дүгнэлт                               | 65            | 2021.05.13            |
| 3 | Ус ашиглах зөвшөөрөл  | A/09          | 2022.04.20            |
| 4 | Ус ашиглуулах дүгнэлт                                       | 30            | 2022.03.14            |
| 5 | Хаягдал усны дүгнэлт  | 06            | 2022.03.10            |
| 6 | Химийн бодисын агуулахын дүгнэлт                            | 05-04-002/130 | 2018.11.02            |
| 7 | Хог хаягдал, бохир ус зайлуулах цэг тогтоох тухай           | A/124         | 2019.10.21            |
| 8 | Тэсэлгээний агуулах хүлээн авах, аюулгүйн бүс тогтоосон акт | 19/32         | 2019.12.04            |

#### 1.6.3 Газар ашиглалтын зөвшөөрөл

*Хүснэгт 6. Газар ашиглах зөвшөөрлүүд*

| № | Газар эзэмших зориулалт   | Гэрчилгээний дугаар | Газрын хэмжээ /га/ | Хүчинтэй хугацаа          |
|---|---|---------------------|--------------------|---------------------------|
| 1 | Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж /Кемп/                      | 000003734           | 3.8 га             | 2017.04.24 а/41<br>15 жил |
| 2 | Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж /Тэсрэх материалын агуулах/ | 000003735           | 3.92 га            | 2017.04.24 а/41<br>15 жил |
| 3 | Уул уурхайн үйлдвэрлэлийн барилга, байгууламж /Үйлдвэрлэл/                | 000003736           | 58.0 га            | 2017.04.24 а/41<br>15 жил |

#### 1.6.4 Байгаль орчны үнэлгээ

*Хүснэгт 7. БОННУ-ний тайлангууд*

| № | БОННУ тайлангийн нэр   | Батлагдсан он |
|---|--|---------------|
| 1 | Хөхбулгийн алт-зэсийн үндсэн ордыг ил болон далд аргаар ашиглах төслийн БОННУ-ний тайлан | 2017          |
| 2 | Хөхбулгийн алт-зэсийн үндсэн ордыг ил уурхайн аргаар ашиглах төслийн БОННУ-ний тайлан    | 2021          |

## 2 ХӨХБУЛАГ УУРХАЙН 2022 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН НИЙТ ЗАРДАЛ

Хамрах хүрээ: Хөхбулаг уурхайн MV-0 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд явагдаж буй үндсэн олборлолт, хүдэр баяжуулалтын үйл ажиллагаанаас гадна дүйцүүлэн хамгаалал, овоолгын техникийн нөхөн сэргээлт, сул зогсолтын үед баяжуулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн ажлуудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2022 онд хэрэгжүүлэх БОМТ-г БОАЖ-ын яамаар батлуулан ажиллаа. Тус уурхайн 2022 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний зардал, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн зардал зэргээс бүрдэх бөгөөд мөн дүйцүүлэн хамгаалал, нөхөн сэргээлтийн ажлын зардалд нийтдээ 46, 717, 760.00 /дөчин зургаан сая долоон зуун арван долоон мянга долоон зуун жаран төгрөг/-ийг төсөвлөснөөс ..... төгрөг зарцуулсан байна.

Хүснэгт 8. БОМТ-ний тайлангийн задаргаа

| №  | Зардлын төрөл   | Дүн (төгрөг)           |
|----|---|------------------------|
| 1  | Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний зардлын биелэлт   | 14,342,178.56          |
| 2  | Нөхөн сэргээлтийн төлөвлөгөөний биелэлт   | 8,440,290.00           |
| 3  | Дүйцүүлэн хамгаалах төлөвлөгөөний биелэлт   | 25,435,113.00          |
| 4  | Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох төлөвлөгөө   | -                      |
| 5  | Түүх соёлын өвийг хамгаалах төлөвлөгөө  | -                      |
| 6  | Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт   | Үйл ажиллагааны зардал |
| 7  | Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөний биелэлт   | 3,135,350.00           |
| 8  | Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн биелэлт   | 4,857,540.00           |
| 9  | Удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө   | Үйл ажиллагааны зардал |
| 10 | Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө | Үйл ажиллагааны зардал |
|    | <b>Нийт дүн</b>   | <b>56,210,471.56</b>   |

## 3 СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

### 3.1 Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт

#### 3.1.1 Технологийн замд усалгаа хийж техникийн ажлын хуудсаар бүртгэлжүүлэх

Уурхайн ашиглалтын зам нь баяжуулах үйлдвэрийн хүдэр тээврийн зам, ил уурхайн зам, хаягдлын сангийн тээвэрлэлт, ус зөөврийн гэх мэт нийт замын урт нь 800 м, замын өргөнийг 9 м –ээр тооцож усны хэрэглээг гаргалаа. 2022 онд уурхай 4-р сарын 30 хүртэл нийт 120 хоног ажилласан бөгөөд бусад хугацаанд сул зогсолт хийсэн болно. 4-р сард нийтдээ 4 удаа замын тоосжилт дарах усалгааг хийсэн бөгөөд БОАЖНХЯ-ны сайдын 2015 оны 07 дугаар сарын 30-ны өдрийн А/301 тоот тушаалын 13-р хавсралтын 7-д баталсан ус хэрэглээний нормын дагуу 1 м<sup>2</sup> зам талбайг 2.0 л усаар усална гэсэн нормоор усны хэрэглээг тооцвол: Уурхайн талбай доторх замын урт нь 800 м буюу 7200 м<sup>2</sup> талбайн 1 удаагийн усалгаанд 7200 м<sup>2</sup>\*2.0 л = 14.4 м<sup>3</sup> ус зарцуулагдана. Сул зогсолтын хугацаанд хүнд даацын автомашин ашиглагдаагүй тул замын усалгаа хийгдээгүй байна. 4 удаагийн усалгаанд ашигласан усны тооцоо: 14.4 м<sup>3</sup>\*4 хоног=57.6 м<sup>3</sup> ус зарцуулсан. **Төлбөрийн тооцоо: 57.6 м<sup>3</sup>\*188.1=10,834.56 төгрөг /Ус ашиглуулах дүгнэлтээс 1м<sup>3</sup> усны үнэлгээг авч тооцов./**

Замын усалгаанд 3.8 тн-ын багтаамжтай ЗИЛ-130 маркийн автомашин, 1 жолооч, 1 туслах ажилтан ажилласан бөгөөд нийтдээ/ус зөөврийн замыг нэмж тооцсон, 3.8 тн нэг удаагийн тээвэр, нийт 16 удаагийн тээвэр хийсэн/28800 м<sup>2</sup> зам талбайг урласан. Замын усалгаанд усны төлбөр 10 834.56 төгрөг, 10 л түлш, 4 ажилчны цалин хөлс, бусад



зардал, нийт **777,334.56 төгрөг** зарцуулав. / 1 хүний өдрийн дундаж цалин 90 000 төгрөг, 1 л түлш 4250 төгрөг-өөр тооцлоо /



Зураг 21. Замын тоосжилт дарах усалгаа хийж буй байдал



Зураг 22. Усалгаа хийгдэж буй замын байршлууд


### **3.1.2 Технологийн замд үүссэн тууринг хусах, техникүүдэд хурдны хязгаарлалт мөрдүүлж замын тэмдэг тэмдэглэгээг сэргээн засварлах**

Уурхайн ашиглалтын талбайн дотоод замуудад үүссэн дэргжигнүүр тууринг өөрсдийн техникээр түрж, хайргаар хучилт хийж тэгшилж зассан бөгөөд уг ажилд бульдозер, утгуурт ачигч нийт 2 техник, 2 оператор ажиллаж, 58 л түлш, 239,540.00 төгрөг зарцуулав. Уурхай доторх ашиглалтын 2 замд 5, 10 км/ц заасан хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээ 2ш-ийг шинээр байрлуулан, ХАБЭА-н мэргэжилтэн тээврийн машины операторуудад хурдны хязгаарыг мөрдөж ажиллах талаар аюулгүй ажиллагааны зааварчилгаа тогтмол өгч ажиллаж байна. Манай компани нь үйл ажиллагааны туршид уурхайн ашиглалтын бүх замуудад хурдны хязгаарын тэмдэг тэмдэглэгээг шаардлагатай газруудад бүрэн байршуулан ажиллаж байна. Шатахуунд **239540 төгрөг** зарцууллаа.





Зураг 23. Шинээр байрлуулсан хурдны хязгаарын тэмдэг




Зураг 24. Замын засвар, арчилгаа хийж буй байдал

**3.1.3 Агаарт физикийн хүчин зүйлийн үзүүлэлтүүд тодорхойлох**


Ажилчид ажлын байрны дуу чимээний бохирдлын нөлөөлөлд өртөж байгаа эсэхийг хянах зорилгоор БНХАУ-д үйлдвэрлэгдсэн Smart Sensor брендийн AR-844 маркийн дуу чимээ хэмжигч багажийг 2019 онд худалдаж авсан ба энэхүү багажаар уурхайн дуу чимээг хэмжиж байна. Мөн Байгаль орчны судалгааны мэргэжлийн байгууллага болох “Эконатур” ХХК-тай байгуулсан 2022 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 04/07 тоот гэрээний дагуу Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсаны дагуу дуу чимээ, агаар орчны тоосны хяналт шинжилгээг 2022 оны 4-р сарын 10, 9-р сарын 25-ны өдрүүдэд тус уурхайн бүсэд хийж гүйцэтгэсэн бөгөөд шинжээч Э.Идэр, хөрсний шинжээч Д.Энхбаяр, ургамал шинжээч Д.Насанбаяр нар ажилласан. Байгууллагын байгаль орчны мэргэжилтэн орчны дуу чимээг улиралд 1 удаа, тогтсон хугацаанд нийт 3 удаа, тоосны шинжилгээг Deinmern маркийн гар багажаар 7 цэгт 1 удаа шинжилгээ хийж шинжилгээний дүнг тайланд хавсаргав. Эконатур ХХК нь Particle counter PCE-PCO маркийн тоос хэмжигч багажаар 4 цэгт 1 удаа тус тус хэмжилтийг хийж үр дүнг ОХШХ-ийн тайланд дэлгэрэнгүй тусгав. Агаар орчны шинжилгээнд нийт 2500000 төгрөг зарцуулав. /Мэргэжлийн байгууллагатай хийсэн гэрээний дүнгээр/




Зураг 25. Тоосны шинжилгээ хийж буй байдал



Зураг 26. Дуу чимээний шинжилгээ



Зураг 27. Тоос хэмжигч



Зураг 28. Дуу чимээ хэмжигч





Зураг 29. Дуу чимээ хэмжиж буй нь

### 3.1.4 Уурхайн гадаад, дотоод тээвэрлэлтийн гол замын сүлжээ, маршрутыг тогтоох, гол замыг сайжруулсан хайрган хучилттай болгох, цаашид арчилж тордох

Уурхайн талбайд ашиглагдаж буй автозамыг тус компанийн үйл ажиллагаа эхэлсэнээс хойш үе шат тайгаар хайрган хучилттай болгох ажлуудыг хийж дуусган, замын байнгын арчилгаа, засварын ажлыг уурхайн ашиглалтын хэсэг хариуцан гүйцэтгэж байна. Уурхайн ашиглалтын зам нь баяжуулах үйлдвэр хоорондын, уурхай хоорондын, кемп хүртэл, ус зөөвөрлөх, тэсэлгээний агуулах хүртэлх замуудаас бүрдэж байна.







Зураг 30. Хайрган хучилттай болгож засварласан замууд



Зураг 31. Замын засвар, арчилгаа хийж буй байдал





Зураг 32. Уурхайн замын сүлжээний зураг

### 3.2 Гадаргын болон газрын доорх усны нөөцөд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний гүйцэтгэл

#### 3.2.1 Усны эх үүсвэрүүдэд эрүүл ахуйн бус тогтоож, самбарыг сэргээн засварлах

Тус компани нь технологийн зориулалтаар болон ажилчдын унд ахуйн зориулалтаар өөрийн хөрөнгөөр гаргуулсан 2 гүн өрмийн худаг ашиглаж үйл ажиллагаагаа явуулж байна. 2022 оны байдлаар Баянхонгор аймгийн хэмжээнд уул уурхайн зориулалтаар ашиглагдаж буй гүн өрмийн худгуудад эрүүл ахуйн бус тогтоогдоогүй боловч тухайн гүн өрмийн худаг гаргуулахад гидрогеологийн судалгаа хийлгэн Усны газраар усны боломжит нөөцийн дүгнэлт гаргуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Тус компанийн хувьд Усны тухай хууль болон БОНХАЖЯамны сайд, Барилга хот байгуулалтын сайдын хамтарсан 2015 оны А-230/127-р тушаалаар батлагдсан Усны сан



бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын, эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдөх журмын 3.8-д заасны дагуу ус хангамжийн эх үүсвэрийн эргэн тойрныг хашиж хамгаалан, 24 цагийн харуул хамгаалалт ажиллуулж, цооногийн бүрэн бүтэн байдлыг хянах, ус түгээх үед зөвшөөрөлгүй хүн оруулахгүй байх санамж зэргийг өгч, ус түгээлтийн бүртгэлийг тогтмол хөтлөн ажиллаж байна.



Зураг 33. Усны эх үүсвэрийн хамгаалалтын байдал

### 3.2.2 Гүний худгуудад тоолууруудын бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах

Гүн өрмийн худгийн харуул хамгаалалтын ажилтан тоолуурын бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьж, ус ашиглалтын бүртгэлийг өдөр бүр хөтлөн, усны тоолуурын хяналтыг “Бөөн цагаан-Орог нуурын сав газрын захиргаа” 2022 оны 7, 10-р саруудад хийсэн бөгөөд усны тоолуурын ажиллагаа хэвийн байсан. 2022 оны 12 сарын 31-ний байдлаар уурхайн хэмжээнд ХБХ-01 худгаас  $3052\text{м}^3$ , ХБХ-02 худгаас  $1415\text{м}^3$  усыг тус тус ашигласан байна. Усны төлбөрт **3500000** төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн.







Зураг 35. Хаягдлын сангийн хуурай үлдэгдэл

**3.2.4 Ус ашиглалтын хууль эрх зүйн бичиг баримтуудын бүрдүүлэлт хийх**

- ✚ Усны боломжит нөөцийн дүгнэлт – МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, 2021 оны 05 сарын 13-ны өдөр, Дугаар 65
- ✚ Ус ашиглах дүгнэлт - МУ-ын ЗГ-ын хэрэгжүүлэгч агентлаг Усны газар, 2022 оны 03 сарын 14-ний өдөр, Дугаар 30
- ✚ Ус ашиглах гэрээ – Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаа, 2022 оны 04 сарын 22, Дугаар 02
- ✚ Усны төлбөрийн баримт – 2022.12.15, 2500000, 2022.10.31, 1000000, нийт 3500000 төг

2021 оны 05 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар... 65** Улаанбаатар хот

**1. Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллага:**  
"Вояжерминерал ресурсес" ХХК, захирал Ц.Бямбацогж, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай, Сантрал тауэр 12-01 тоот, утас: 321914, улсын бүртгэлийн дугаар: 9011299047, регистрийн дугаар: 5502292

**2. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ боловсруулсан аж ахуйн нэгж, байгууллага:**  
"Ашид Ананда" ХХК, холбоо барих утас: 88110104, 99127937.

**3. Төслийн нэр, байршил:**  
Хөх булаг алт, зэсийн орд ашиглах төсөл, Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт Бөөнцагаан нуур, Байдраг голын сав газарт оршино.

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар, үйлдвэрлэл, үйлчилгээний нэр, төрөл, зориулалт:**  
Ашигт малтмал ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар: MV-020591, Уул уурхай, Алт, зэсийн орд.

**6. Төслийн хүчин чадал, ажиллах горим:**  
Төсөл 1 жил үргэлжилнэ. 89,740.0 тн хүдэр баяжуулах ба 260 хоног ажиллана.

**7. Усны эх үүсвэр, байршил:**  
- Газрын доорх ус /3 худаг/  
№ Уртраг Өргөрөг  
1 99°34'49.24" 46°19'36.93"  
2 99°35'42.33" 46°20'55.44"  
3 99°35'43.35" 46°20'55.56"

**8. Ашиглах усны хэмжээ:**  
Ус ашиглалтын тооцоо:  
- Технологийн хэрэгцээнд нийт 341,012.0 м³/хон ус шаардлагатай бөгөөд ашиглах усны 80 хувь буюу 272,809.6 м³/хон усыг эргэлтээр, нөхөн сэлбэлтээр 20 хувь буюу 68,202.4 м³/хон усыг авч ашиглана.  
89,740.0 тн/хон х 3.8 м³/тн х 20% = 262.31 м³/хон (68,202.4 м³/жил);  
- Ажилчдын унд ахуйд: 153 хүн х 80 л/хон = 12.64 м³/хон (3,286.4 м³/жил);  
- Зам, талбайн усалгаа: 10,946.7 м² х 2 л/м² = 21.89 м³/хон (1,970.1 м³/жил);  
- Өрөмдлөг 58,752 м х 0.1 м³/м = 65.28 м³/хон (5,875.2 м³/жил);  
**Нийт 362.12 м³/хон (79,334.1 м³/жил) ус шаардагдана.**

Олборлолт дууссаны дараа жилээс биологийн нөхөн сэргээлт хийх ба 2 жил усалгаа хийнэ. Жилд 5,427.2 м³ ус ашиглана.

**9. Дүгнэлт:**  
Төсөл хэрэгжүүлэхэд шаардагдах 362.12 м³/хон усыг өөрийн эзэмшлийн 6.5 л/с буюу 561.6 м³/хон нийлбэр ундаргатай 3 худагсаа хангахад усны ашиглах боломжит нөөц хүрэлцээтэй байна.

**10. Төвийг шаардлага, цаашид авах арга хэмжээ, зөвлөмж:**  
Төслийг хэрэгжүүлэхдээ "Усны тухай" хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, 28 дугаар зүйлийн 28.4, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийг хэрэгжүүлж ажиллахыг "Вояжерминерал ресурсес" ХХК-д зөвлөж байна.

ДүГНЭЛТ ГАРГАСАН МЭРГЭЖИЛТЭН Д.БАТЖАРГАЛ

Зураг А. Усны боломжит нөөцийн дүгнэлт

2022 оны 03 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар-30** Улаанбаатар хот

**УС АШИГЛУУЛАХ ДҮГНЭЛТ**

**1. Аж ахуйн нэгж, байгууллага, захирлын нэр, хаяг, утас, факс, улсын бүртгэлийн дугаар болон регистрийн дугаар –**  
"Вояжер Минерал Ресурсес" ХХК, гүйцэтгэх захирал Ц.Бямбацогж, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимпы-5, Асуд тауэр, 10047тоот, Утас 99001441, И-мэйл: info@vmt.mn, улсын бүртгэлийн дугаар: 9011299047, регистрийн дугаар: 5502292.

**2. Төслийн нэр, байршил –**  
"Хөх булагийн алт-зэсийн үндсэн орд" ил уурхайн аргаар ашиглах төсөл нь Баянхонгор аймгийн Бөмбөгөр сумын нутагт, Улаанбаатар хотос баруун зүгт 750км, Баянхонгор аймгийн төвөөс баруун зүгт 120км, Бөмбөгөр сумын төвөөс хойш 20 км-т байрлана. Бөөнцагаан нуур, Байдраг голын сав газарт хамаарагдана.

**3. Төсөл хэрэгжүүлэгч –**  
"Вояжер Минерал Ресурсес" ХХК;

**4. Тусгай зөвшөөрлийн дугаар болон талбайн координат /X,Y/ –**  
Тусгай зөвшөөрлийн дугаар MV-020591, Талбайн хэмжээ: 791.61га  
№ Уртраг Өргөрөг  
1 99°36'0.48" 46°20'21.58"  
2 99°34'0.48" 46°20'21.58"  
3 99°34'0.48" 46°22'01.58"  
4 99°36'0.48" 46°22'01.58"

**5. Үйлдвэрлэл, үйлчилгээний нэр төрөл, зориулалт –**  
Алт-зэсийн үндсэн орд" ил аргаар олборлох, баяжуулах.

**6. Үйлдвэрийн техник, технологи /ажиллах горим, хүчин чадал/ –**  
Хаягуулах үйлдвэрт PE400-600 маркийн хацарт бутлуур 1ш, GP-100 маркийн конусан бутлуур 1ш, YZ10-20 маркийн чинчиргээт шилшүүр 1ш, BELT-400 маркийн туузан конвейер 1ш, MOGJ-150 маркийн бөөрөнцөг тээрэм, FLG1500 маркийн бүнкер тэжээх төхөөрөмж, SP-4 болон SP-2.8 маркийн пневмомеханик флотаци 2ш, өтгөрүүлэх, шүүх, хатгах төхөөрөмж 3ш, 650-р маркийн насос 1ш ажиллана. Уурхайн сэлтэрлэг болон huynдай маркийн экскаватор 3ш, LILONGONG маркийн утгуур аягч 1ш, SHANTUI маркийн бульдозер 1ш, HF385Y өрмийн машин 1ш, HOWO болон NORTHBENZ маркийн автосамосал бш ажиллана. 2022 онд 177 хүн 2 ээлжээр, ээлжинд 12 цагаар ажиллана. Ил уурхай 92 хоног, баяжуулах үйлдвэр 160 хоног ажиллана.

**7. Үйлдвэрлэх, боловсруулах бүтээгдэхүүний хэмжээ –**  
2022 онд шинээр 4-р хүдрийн биетээс 15,890.0тн хүдэр, 2021 оны үлдэгдэл болох 5-р хүдрийн биетийн олборлолтоос үлдсэн 10,000.0тн хүдэр, нийт 25,890.0тн хүдэр баяжуулж, 49.3кг алт, 90тн зэс, 220.96кг мөнгө авахаар төлөвлөсөн. Биологийн нөхөн сэргээлт 5,653.9м³ талбайд хийгдэнэ. "Тарбум мод" үндэсний жидвэлгөөний хүрээнд 300ш мод тарина.

**8. Усны эх үүсвэр, нөөц, чанар, хонот ашиглах хэмжээ /шоо,мөтэрээр/ –**  
Унд ахуй, технологийн хэрэгцээ, зам талбайн тосгожилт дарак, Биологийн нөхөн сэргээлтэд ашиглах усыг өөрийн эзэмшлийн нийт 6.5л/с-аар ундаргатай 3ш гүний худагсаа хангана. "Усны

Зураг Б. Ус ашиглуулах дүгнэлт



Байгаль орчин, ногоон хөгжлийн сайдын 2013 оны 12 дугаар сарын 20-ний өдрийн А-367 тоот тушаалын хавсралт

**БАТЛАВ.**  
БӨӨНЦАГААН-ОРОГ НУУРЫН САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, Б.НЯМЧИР  
УС АШИГЛАХ ГЭРЭЭ

**БАТЛАВ.**  
"ВОЯЖЕР МИНЕРАЛ РЕСУРСЕС"-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ХАРИУЦСАН ЗАХИРАЛ Б.БАТЦЭНГЭЛ  
УС АШИГЛАХ ГЭРЭЭ

2022 оны 04 дүгээр сарын 22 Дугаар 02 Номгон

**НЭГ. Ерөнхий зүйл**  
Усны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.4, 28.6, 28.7, 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалт, Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2021 оны 06 дугаар сарын 21-ны өдрийн 05/515 дугаартай ус ашиглуулах дүгнэлт, Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргааны 2021 оны 07 дугаар сарын 02-ний өдрийн А/15 тоот тушаалаар олгосон ус ашиглах зөвшөөрлийг тус тус үндэслэн  
Ус ашиглуулагчийг төлөөлж Бөөнцагаан-Орог нуурын сав газрын Захиргааны мэргэжилтэн Э.Жамц  
Ус ашиглагчийг төлөөлж Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Олимп-5, Аюудтауэр, 1002 тоот, утас:98001441, Улсын бүртгэлийн дугаар:9011299047, регистрийн дугаар:5502292, "Вояжер Минерал Ресурсес" ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирал Б.Батцэнгэл нар ус ашиглах талаар тохиролцон энэхүү гэрээг 2022 оны 11 дугаар сарын 01-ний өдрийг хүртэл хугацаатайгаар байгуулав.

**ХОЁР. Гэрээний нөхцөл**  
2.1 Хүн ам, үйлдвэрийн хэрэгцээнд  
2.2 Ашиглах усны хэмжээ – 34,413.2м³  
2.2.1 Унд ахуй- 7,123.0м³  
2.2.2 Үйлдвэрлэл- 19,524.8м³  
2.2.3 Үйлчилгээ /тоосжилт дарах/ - 2,240.4м³  
2.2.4 Биологийн нөхөн сэргээлт - 5,427.0 м³  
2.3 Усны чанар найрлага: Үйлдвэрийн болон унд ахуйн усанд гидрхимийн шинжилгээг итгэмлэгдсэн байгууллагаар хийлгэж, шинжилгээний хариуг улирал тутамд Бөөнцагаан-Орог нуурын сав газрын захиргаанд ирүүлэх  
2.4 Усны эх үүсвэрийн байршил: Унд ахуйн болон технологийн хэрэгцээний усыг уурхайн талбайд байрлах 3 гүний худгаас хангана.

Зураг В. Ус ашиглах гэрээ

9:13:23, 3:26 PM Шилжихийн үргэлэлт

**Худалдаа Хөгжлийн Банк** Огноо: 2023.01.13 15:26:45

**Шилжүүлгийн мэдээлэл**  
Журналын №: 83992144

Системийн огноо: 2022.12.15

Нэр: **ВОЯЖЕРМИНЕРАЛ РЕСУРС ХХК**

|                                       |                          |                                    |                       |            |
|---------------------------------------|--------------------------|------------------------------------|-----------------------|------------|
| Илгээгч                               | Дансны дугаар: 891003267 | Нэр: ВОЯЖЕРМИНЕРАЛ РЕСУРС ХХК      | Дүн: 2,500,000.00 MNT | Ханц: 1.00 |
| / хоёр сав таван зуун мянган төгрөг / |                          |                                    |                       |            |
| Хүлээ авэгч                           | Банкны дугаар: 04        | Банкны нэр: Худалдаа Хөгжлийн Банк | 2,500,000.00 MNT      | 1.00       |
|                                       | Дансны дугаар            | Нэр                                |                       |            |

Гүйлгээний утга: **ЕВ -3220902139675-Үйлдвэрлэл, үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр-6**

**Танд байрлалаа**

**Гүйлгээний баримтыг баталгаажуулсан**  
Салбар, тооцооны төв: Гэрэн усаг:  
Танга:  
Огноо: \_\_\_Он \_\_\_Сар \_\_\_Өдөр

**ГОЛОМТ БАНК**  
Байр олонжлоо төлөөрөө

**Пахим гүйлгээний баримт**

